



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/391

Булган сум


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн эмнэлгийн Цусны салбар төвийн тусламж үйлчилгээг сайжруулах, цус цусан бүтээгдэхүүний бэлэн байдал, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай төхөөрөмжийг нэн даруй хангахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Төхөөрөмжийг авахад шаардлагатай 1,390,000 (нэг сая гурван зуун ерэн мянга) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ